



## Монголын урлагийн байгууллага, уран бүтээлчдийн анхааралд!

Нээлттэй Нийгэм Хүрээлэн \Соросын сан\-ийн Соёл Урлагийн Бүсийн Хөтөлбөр, Монголын Урлагийн Зөвлөл /МУЗ/ хамтран “**Соёл урлагийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх**”, “**Олон нийтэд зориулсан соёлын орон зайг хөгжүүлэх**” гэсэн ерөнхий хоёр сэдвийн хүрээнд дараах дөрвөн чиглэлээр төсөл шалгаруулах уралдаан зарлаж байна. Уралдааны зорилго нь соёл урлагийн хамтарсан төслүүдээр дамжуулан **Армени, Азербайжан, Гүрж, Киргизстан, Узбекистан, Казахстан, Монгол, Тажикистан, Туркменистан, Турк, Афганистан** зэрэг орнуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, соёл урлагаар дамжуулан дэлхий дахин, бүс нутаг болон тухайн орны хөгжилд болон нээлттэй нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.

### 1. Соёл урлагийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх

#### Төсөл боловсруулах чиглэл:

- **Мэргэжил дээшлүүлэх тэтгэлэг**

Энэ чиглэлд дээрх орнуудын соёл урлагийн удирдлага, менежмент, бодлогын салбарт ажилладаг ажилчид, уран чадавхийг дээшлүүлэх төслүүд хамаарагдана. Тус тэтгэлийг дугуй ширээний ярилцлага, семинар, сургалт, соёл болон урлаг судлалын чиглэлээр хийгдэх судалгаа болон бусад соёл урлагийн салбартай холбоотой судалгаанд олгоно. Тэтгэлэг хүсэгч нь өөрийн мэргэжлийн ур чадварыг тухайн төслөөр дамжуулан хэрхэн дээшлүүлэх талаар тодорхой тусгаж өгнө.

Дараах зардлуудад тус тэтгэлгийг олгоно. Үүнд: Замын зардал, дугуй ширээний ярилцлага, семинар, сургалтын төлбөр, өргөдөлд дурдсан хугацааны байр, хоол, унааны зардлыг олгоно. Тэтгэлгийн дээд хэмжээ **\$10,000 ам доллар** бөгөөд тэтгэлгийг техник төхөөрөмж худалдан авахад болон ажлын хөлс болгон ашиглахыг хориглоно. Тэтгэлгийг зарцуулах хугацаа, зорчих улсыг хязгаарлахгүй болно. Тэтгэлэг хүсэгч нь оролцохыг хүссэн олон улсын үйл ажиллагааны албан ёсны урилгыг ирүүлнэ. Мөн олон улсын судалгаа хамтран бүтээх байгууллага, уран бүтээлчээс ирүүлсэн албан тоотыг хавсаргана.

- **Соёл урлагийн хамтарсан уран бүтээл туурвих тэтгэлэг**

Энэ чиглэлд дээрх дурдсан орнуудын уран бүтээлчдийн мэргэжлийн өндөр түвшинд хамтын уран бүтээл туурвих төслүүд хамрагдана. Уг тэтгэлэг нь урлагийн бүх төрлийн бүтээлч үйл ажиллагааг дэмжинэ. Үүнд: Хөгжим, дүрслэх урлаг, малтимедиа, театр, кино драм, радио, хүүхэлдэйн театр, хүүхэлдэйн киноны төрөл багтана. Хамтарсан төслийг олон улсын уран бүтээлчид, олон нийттэй хамтран урлагийн дээрх төрлөөр хэрэгжүүлэх боломжтой. Тэтгэлэг хүссэн төслүүд нь урт хугацааны, тогтвортой, нийгэмд эерэг үр дагвар бий болгох зорилгыг агуулсан байна. Тэтгэлгийн дээд хэмжээ **\$25,000 ам доллар**

#### Олон нийтэд зориулсан соёлын орон зайг хөгжүүлэх

- **Соёл урлагийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх тэтгэлэг**

Энэ чиглэлд дээрх орнуудын соёл урлагийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, бие даасан соёлын орон зайг хөгжүүлэх чиглэлийн төслүүд хамаарагдана. Уг тэтгэлийг нь 3 жил хүртэл хугацаанд нэг байгууллагад олгох боломжтой. Тэтгэлэгийг соёл урлагийн салбарын байгууллагын хөгжил, шинэ үзэгчдийг бий болгох, хөгжлийн бэрхшээлттэй иргэд, үндэсний цөөнх болон бусад нийгмийн бүлэгт соёл урлагийн үйлчилгээг хүргэх,

удирлага болон менежментийн чадавхийг дээшлүүлэх зорилготой төслүүдэд олгоно. Тэтгэлэг хүсэгч нь байгууллага нь байгууллагын чадавхийг дээшлүүлэх 3 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулж, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсаргана. Мөн тухайн байгууллагын танилцуулга, ажилчдын тоо, жилийн төсөв, хамтран ажиллагсад, орлогын эх үүсвэр болон байгууллагын гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Тэтгэлгийн дээд хэмжээ **\$25,000**

- **Олон нийтийн соёл урлагийн арга хэмжээнд олгох тэтгэлэг**

Энэ чиглэлд олон нийтийн соёл урлагийн арга хэмжээ, наадам, тоглолт, цуврал хэлэлцүүлэг, лекц, мэтгэлцээн зохион байгуулах болон дээрх арга хэмжээнд зориулагдсан тандалтын судалгаанууд хамрагдана.

Тухайн олон нийтийн соёл урлагийн арга хэмжээ нь удаан хугацаанд тогтвортой үр нөлөө үзүүлж чадахуйц байх шаардлагатай. Тэтгэлэг хүсэгч нь тухайн арга хэмжээний зорилго, хэрэгжилтийн нарийвчилсан стратеги төлөвлөгөө болон цаашдын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг ирүүлнэ. Мөн тус арга хэмжээний үзэгчдийг тодорхойлж, тэдэнд тухайн арга хэмжээ хэрхэн хүрч, тэднийг хэрхэн оролцуулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ. Тэтгэлгийн дээд хэмжээ **\$10,000**

### **Уралдааны журам, заавар**

- Уралдаанд дээр дурдсан орнуудын соёл урлагийн байгууллага, уран бүтээлчид оролцоно.
- Урьд өмнө нь ННХ /Соросын сан/-ийн Соёл Урлагийн Бүсийн Хөтөлбөр, МУЗ-өөс тэтгэлэг авч байсан байгууллага, хувь хүмүүс урьд өмнө хэрэгжсэн төслийн санхүүгийн тайлан болон бусад холбогдох материалыг бүрэн хүлээлгэн өгсөн тохиолдолд оролцож болно.
- Төслийг дээр дурьдсан аль нэг чиглэлээр боловсруулах ба нэгээс дээш чиглэлээр төсөл боловсруулах тохиолдолд тус бүрд нь боловсруулах шаардлагатай. Тэтгэлгийн хэрэгжилтийн хугацаанд хүлээн авсан санхүүжилт бүрийн эцэст санхүүгийн болон үйл ажиллагааны нарийвчилсан тайлан гаргана.
- Төслийг англи хэлээр боловсруулах ба орос хэлээр боловсруулах тохиолдолд төслийн нэг хуудас товч танилцуулгыг англи хэлээр хийж хавсаргана.
- Төсөл нь төсөвтэйгээ нийлээд А4 цаасны таваас дээшгүй хуудастай байх ба Times New Roman шрифтээр, үсгийн 12 хэмжээтэй байна.
- Нийт төсвийн 30% хүртлэх санхүүгийн бусад эх үүсвэрээс бүрдүүлэх шаардлагатай.
- Тухайн төслийг хамтран хэрэгжүүлэх, санхүүжүүлэх байгууллагын албан ёсны захидлыг хавсаргана.
- Төсөл бичих заавар болон өргөдөлийн маягтыг [www.soros.org/initiatives/arts](http://www.soros.org/initiatives/arts) вэб хаягаар болон МУЗ-ийн Тэтгэлгийн зохицуулагч Б. Номинтуяатай 319015, 319017 тоот утсаар холбогдож доорх хаягаар ирж авна уу.

### **Төсөл хүлээн авах хугацаа, сонгон шалгаруулалт**

- Уралдаанд ирүүлэх төслүүдийг **2008 оны 9 сарын 15 наас 2010 оныг дуустал** МУЗ-ийн Хөтөлбөр зохицуулагч Б. Номинтуяад [marketing@artscouncil.mn](mailto:marketing@artscouncil.mn) и-мэйл хаягаар явуулна. И-мэйлээр явуулах боломжгүй тохиолдолд факсаар буюу МУЗ-ийн доорх хаягаар ирүүлнэ.
- Уралдаанд ирүүлсэн бүх төслөөс анхан шатны шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг Будапешт дахь ННХ /Соросын Сан/-ийн Соёл Урлагийн Бүсийн Хөтөлбөрт явуулах ба эцсийн шалгаруулалтыг Бүсийн Хөтөлбөрийн Шинжээчдийн Дэд Зөвлөл шалгаруулна.
- Уралдааны дүнг **төсөл ирүүлсэн хугацаанаас 4 сарын дараа** мэдэгдэх ба мөн [www.soros.org](http://www.soros.org) вэб хуудаснаас харж болно.

**Танд төсөл боловруулахад туслалцаа хэрэгтэй байна уу?**

Нээлттэй Нийгэм Хүрээлэн \Соросын сан\-ийн Соёл Урлагийн Бүсийн Хөтөлбөр, Монголын Урлагийн Зөвлөл /МУЗ/ хамтран “Төсөл хэрхэн бичих вэ?” хөтөлбөрийг танилцуулж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид Танд дараах асуудалаар зөвлөгөө өгнө.

Үүнд:

- Өргөдөлийн маягт болон өргөдөл хүлээн авах үйл явцтай илүү сайн танилцахад туслах.
- Төслийн ерөнхий санааг томъёолж, төслийн тодорхой зорилго зорилтыг боловсруулах
- Төслийг чанартай бодитой зөв боловсруулах
- Бодитой, тодорхой, үнэн төсөв боловсруулах
- Бодитой үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Тухайн төсөлд хамтран ажиллах байгууллага, хувь хүмүүсийн мэдээлэлийг Монголын болон Нээлттэй Нийгэм Хүрээлэн \Соросын сан\-ийн Соёл Урлагийн Бүсийн Хөтөлбөр хэрэгждэг улс орнуудын хүрээнд зөвлөгөө өгөх
- Санхүүгийн бусад эх үүсвэр хэрхэн олох талаар зөвлөгөө өгөх
- Төслийн боловсруулах болон хэрэгжилийн явцад зөвлөгөө өгөх

Дээрх зөвлөлгөө нь тэтгэлэг хүсэгчдэд үнэ төлбөргүй ба э-шуудан, утас болон биечлэн уулзах зөвлөлгөөг долоо хоног бүрийн Пүрэв гаригийн 15-17 цагийн хооронд авах боломжтой.

Зөвлөлгөөг урьдчилан МУЗ-ийн Хөтөлбөрийн туслах Б. Оюунсүрэнтэй 11-319015 дугаарын утсаар холбогдон өдөр, цагыг товлон, бүртгүүлэх боломжтой.

**Манай хаяг:**

Монголын Урлагийн Зөвлөл  
Дельта Төвийн 4-р давхар /Урт Цагааны зүүн урд талд/  
Утас: 976-11-319017  
Факс: 976-11-319015  
Э-шуудан: [marketing@artscouncil.mn](mailto:marketing@artscouncil.mn)  
Вэб хаяг: [www.artscouncil.mn](http://www.artscouncil.mn)